



ТА БИДНЭЭС:
БЗДХ, ХДХВ-ийн
халдвараас урьдчилан
сэргийлэх мэдлэг,
мэдээлэл, зөвлөгөө,
эрүүл мэндийн тусlamж
үйлчилгээний талаарх
мэдээлэл зөвлөгөө,
зуучлал, сэтгэл зүйн
зөвлөгөө, хүний эрхийн
талаарх мэдээлэл авах
боломжтой юм.

ХОЛБОО БАРИХ

Хаяг: БЗД, 2-р хороо, Их тойруу
112-1,
Ундрам плаза 405 тоот
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: 99267001

zorigsanaa_zorigsanaa@yahoo.com

ШИНЭ ӨӨДРӨГ АМЬДРАЛ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА




ТАНИЛЦУУЛГА

"Шинэ өөдрөг амьдрал" ТББ нь 2008 оны 11-р сард Монголд ХДХВ, ДОХ-ын халдвартай амьдарч буй олон нийтийн үүсгэл санаачилгаар байгуулагдсан бөгөөд одоогоор үйл ажиллагаандаа Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 80 гаруй хүнийг татан оролцуулж байна.

Үүсгэн байгуулагдсанаас цагаас хойш Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслөөс халдвартай олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны санхүүжилт авч, тогтвортой ажиллаж байна.

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО

Монгол дахь ХДХВ, ДОХ-ын халдвартай амьдарч буй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах, ялгаварлан гадуурхалтын бүхийл хэлбэрээс ангид байлгах, тэдгээр хүмүүсийн нийгэмд идэвхтэй байр суурь эзлэхэд туслах, ХДХВ, ДОХ, БЗДХ-ын тархалтыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулахад гол үйл ажиллагаагаа чиглүүлж байна.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- ❖ ХДХВ-ийн халдвартай амьдарч буй олон нийтийг нийтлэг эрх ашгийг хамгаалах
- ❖ Олон нийтийн дуу хоолойг нийгэмд хүргэх, ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолын эсрэг нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- ❖ Олон нийтийн нийгмийн болон эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудыг бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэх
- ❖ Эрүүл зөв идэвхтэй амьдралын дадал хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, чадваржуулах үйл ажиллагааг олон нийт болон гэр бүлийнхэнд зохион байгуулах
- ❖ Бусад энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг, төрийн болон төрийн бус, олон улсын, эрүүл мэндийн байгууллагуудтай олон нийтийн эрх ашгийг хамгаалах дэмжлэг үзүүлэх чиглэлээр тогтмол хамтран ажиллах

ХҮНИЙ НӨӨЦ

Байгууллагын хүний нөөцийн хувьд цомхон чадварлаг багаар олон нийтэд чиглэсэн ажил үйлчилгээг чанартай хүргэхийг зорьдог бөгөөд ХДХВ, ДОХ-ын чиглэлээр З-аас дээш жил ажилласан, мэргэжил дээшлүүлсэн хүмүүс байдаг.



ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Олон улсын болон дотоодын байгууллагуудын судалгаа, мэдээлэл, халдвартай олон нийтийн тохиолдлын илрэх давтамж, хамрах хүрээ, нийгмийн сэтгэл зүй зэргээс ХДХВ-ийн халдвартай олон нийтийн тоо цаашид нэмэгдэх хандлагатай байгаа тул эдгээр хүмүүсийн өвөрмөц хэрэгцээг хангахуйц онцлог үйл ажиллагаа, үйлчилгээг цогцоор нь бий болгох төлөвшүүлэх нийгмийн шаардлага зайлшгүй урган гарч байна.